ТӨРИЙН БАНК
ИТГЭЛ ТӨГС НОГООН ИРЭЭДҮЙ

# БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

| | |
|---|---|
| Огноо (он, сар, өдөр): | 2026.04.17 |
| Үнэт цаас гаргагчийн нэр: | Төрийн банк ХК |
| Үнэт цаасны нэр, код (МХБ симбол): | SBM |
| Салбарын ангилал: | Санхүү |
| Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон толгой болон охин компаниудын мэдээлэл): | Төрийн банк ХК |
| Тайлангийн хамрах хугацаа: | 2025.01.01-2025.12.31 |
| Тайланг баталгаажуулсан гүйцэтгэх удирдлагын мэдээлэл (нэр, албан тушаал): | Өлзий-оргил Гантөр<br>Төрийн банкны Гүйцэтгэх захирал |
| Гүйцэтгэх удирдлагын гарын үсэг: | ..... |
| Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих имэйл хаяг, утас: | Энхэрдэнэ овогтой Энх-эрдэнэ<br>Тогтвортой хөгжлийн албаны менежер,<br>enkherdene.a@statebank.mn, 99102395 |

| Код | Бүлэг | Шалгуур үзүүлэлт | | Үзүүлэлт 2024 он | Үзүүлэлт 2025 он | Хэмжих нэгж | Нэмэлт мэдээлэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| MS | ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМТЭЙ ХОЛБООТОЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД | | | | | | |
| MS1.1 | Тогтвортой хөгжлийн удирдлагын систем | Удирдлагын амлалт | Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх | Тийм | Тийм | | Төрийн банк нь Монгол улсын Тогтвортой санхүүгийн үндэсний замын зургийн зорилтын дагуу “Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого”-д 2030 онд ногоон зээлийн багцыг нийт зээлийн багцын 10%-д хүргэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна.<br>Мөн UN Global compact буюу Даян дэлхийн гэрээнд нэгдэн 4 бүлэгт 10 зарчмыг дагаж мөрдөн ажиллаж байна. Түүнчлэн ToC холбооны гишүүн байгууллага болсноор ToC-ын 8 зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. |
| MS2.1 | | Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт | Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх | Тийм | Тийм | | Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор “Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого”-ыг 2022 онд баталж, 2023 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан.<br>Бодлогын линк: https://heyzine.com/flip-book/5d06cf0287.html |
| MS2.2 | | Бүтэц удирдлага | Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх | Тийм | Тийм | | Тогтвортой хөгжлийн хороо 2023 онд шинээр байгуулагдсан, нийт 5 гишүүдтэй, хорооны гишүүдийн жендэрийн харьцаа 60:40 (эр/эм). Хамгийн багадаа улиралд 1 удаа хуралдаж, Тогтвортой хөгжлийн чиглэлээрх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэдэг. |
| MS3.1 | | | ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх | Тийм | Тийм | | “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын ажиллах журам” -ыг ТУЗ-ийн 2023 оны 13 дугаар тогтоолын хавсралтаар шинэчлэн батлаж, журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Эрсдэлийн удирдлагын хороо ажиллахаар тогтсон. Эрсдэлийн удирдлагын хорооны эрхлэх асуудлын хүрээнд банкны үйл ажиллагааг байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлийг удирдах асуудал хамаарч байгаа тул БОНЗ-ын асуудлыг ТУЗ-ийн 3 гишүүн хариуцан ажиллаж байна.<br>Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн, хорооны гишүүдээр ердийн гишүүн 1, хараат бус гишүүн 1 ажиллаж байна. |
| MS3.2 | | | Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх | Тийм | Тийм | | Тогтвортой хөгжил хариуцсан дэд захиралтай бөгөөд Тогтвортой хөгжлийн албыг шууд удирдлагаар ханган, Тотвортой хөгжлийн хорооны даргаар ажилладаг. |
| MS3.3 | | | Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх | Тийм | Тийм | | Төрийн банк 2023 онд шинээр Тогтвортой хөгжлийн албыг байгуулсан бөгөөд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан бүтэн цагийн ажилтнуудтай. |
| MS3.4 | | | Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг уу? | Тийм | Тийм | | ТУЗ-өөс баталсан “Төрийн банкны байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого”-ын 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Банкны тогтвортой санхүүжилтийн асуудал хариуцсан нэгж нь санхүүгийн тайлагналтай уялдуулан жилд нэг удаа БОНЗ-ын бодлогын хэрэгжилтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд тайлагнана” гэж тус заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын хэлэлцэх асуудалд Банкны үйл ажиллагааны тайланд Тогтвортой хөгжил болон бодлогод заасан үйл ажиллагааны чиглэлээр хийгдсэн ажлуудыг тусгаж тайлагнаж байна. |
| MS3.5 | | Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ | Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх | Тийм | Тийм | | Төрийн банк нь 2024 онд зөвлөх үйлчилгээний байгууллагатай хамтран материаллаг байдлын үнэлгээ /давхар материаллаг байдлын матриц/-ыг гарган ажилласан.<br>Дэлгэрэнгүйг Төрийн банкны Тогтвортой хөгжлийн 2025 оны тайлангийн “Материаллаг сэдвүүд” хэсгээс үзнэ үү.<br>Мөн банк нь “Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого”, “Зээлийн үйл ажиллагааны журам” зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон зээлдэгчдийн зүгээс байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, бууруулах зарчмыг баримтлан ажиллаж байна. |
| MS4.1 | | Чадавх бүрдүүлэлт | Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр | 7.6 | 3.3 | цаг | Банк 2025 онд тогтвортой хөгжлийн чиглэлээр 21 удаагийн 4’720 цагийн сургалтыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, /Банкны төв - 91, УБ - 621, ОН - 740 / нийт 1452 ажилтан хамрагдсан. Нэг ажилтанд ногдох сургалтын дундаж хүн цаг 3.25 ба сургалтад хамрагдсан ажилтнуудыг хүйсээр авч үзвэл (79% эмэгтэй, 21% эрэгтэй) ажилтан хамрагдсан. Мөн бие даан суралцах гарын авлага материал бэлтгэн цахим сургалтын E-Learn программд байршуулсан ба нийт 5 багцын хүрээнд “ Тогтвортой хөгжилд чиглэсэн ” 20 бүлэг сэдэв, 4 цаг 15 минут үргэлжлэх хичээлийг видео хэлбэрт шилжүүлэн цахим сургалтын E-Learn программд байршуулсан. |
| MS4.2 | | Хяналт | Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу? | Тийм | Тийм | | “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын ажиллах журам”-ыг ТУЗ-ийн 2023 оны 13 дугаар тогтоолын хавсралтаар шинэчлэн батлаж, журмын дагуу банкны үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлийг удирдах чиглэлээр Эрсдэлийн удирдлагын хороо үйл ажиллагаагаа явуулахаар, мөн журмын 3.2 дахь хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан банкны бодлогын хэрэгжилтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо хариуцан ажиллахаар тусгасан. |

| Код | Бүлэг | Шалгуур үзүүлэлт | | Үзүүлэлт 2024 он | Үзүүлэлт 2025 он | Хэмжих нэгж | Нэмэлт мэдээлэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| **MS4.3** | | Тогтвортой байдлын тайлагнал | Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу? | Тийм | Тийм | | Банк тогтвортой хөгжлийн талаар жилийн тайланд тусгадаг бөгөөд 2023 оноос эхлэн Тогтвортой хөгжлийн тайланг тусад нь тайлагнаж нийт 3 удаагийн тайлан гаргасан.Линк: https://www.statebank.mn/sustainability/news/21547 |
| **MS5.1** | **Тогтвортой хөгжлийн удирдлагын систем** | | Танай компани олон улсын уур амьсгалын эрсдэлийн стандартын дагуу тайлагнадаг уу? | Үгүй | Үгүй | | Банк нь тогтвортой хөгжлийн тайлагналыг олон улсын стандартад нийцүүлж, тайлагнах ажлын хүрээнд шинээр батлагдсан S1 Тогтвортой байдлын тайлагналын стандарт, S2 Уур амьсгалын эрсдэлийн тайлагналын чиглэлээр Зөвлөх үйлчилгээг авсан.<br>Эрнст энд Янг байгууллагаар зөрүүгийн шинжилгээ хийлгэж, тайлагнахаар зорилт тавин ажиллаж байна. Мөн бүрэн тайлагнах ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээ авах, бэлтгэл ажлыг хангуулах зэргээр энэ чиглэлд нэмэлт ажлууд хийгдэж байна. |
| **MS5.2** | | Гишүүнчлэл, хамтын ажиллагаа | Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу? | Тийм | Тийм | | 1. Монгол улсын Тогтвортой санхүүгийн холбоо, 2. НҮБ-ын Даян дэлхийн гэрээ-UN Global compact, 3. PCAF-Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэл байгуулагч, 4. Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо, 5. Тэрбум мод сан, 6. WE Finance code- Санаачлага, 7. Монголын ногоон санхүүгийн корпораци, 8. Жерес олон улсын байгуулага, 9. Байгалийн өв сан, 10. Ногоон барилгын хүрээлэн ТББ, 11. Монголын амины орон сууцны инновацн хөгжлийн төв, 12. Монголын бэлчээр ашиглагчдын холбоо, 13. Монголын бэлчээр судлалын Ногоон алт ТББ |
| MS6.1 | **БАЙГАЛЬ ОРЧНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД** | | | | | | |
| E1.1 | **Эрчим хүч** | Нийт эрчим хүчний хэрэглээ | Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал | 4,457.3<br>3,227,361.8 | 8,888.7<br>3,665,965.3 | Мега Втц ‘000 | Банк 2024 оноос нийт салбар, нэгжийн эрчим хүчний хэрэглээг нэмж тусган тайлагнаж байгаа бөгөөд 2025 онд банкны хэмжээнд нийт 8,888.7 Мега Втц эрчим хүчийг ашигласан.<br>Цахилгаан, дулаан болон цахилгаан үүсгүүрийн хувьд нийт 3.6 тэрбум төгрөгийн зардал гарсан.<br>Нийт эрчим хүчний хэрэглээг цахилгаан, дулаан болон түлшний энергийг цахилгаан эрчим хүч рүү шилжүүлэв.<br>1 Мега Втц = 1,000 кВт·ц<br>1 Гкал = 1,163 кВт·ц<br>1 литр дизель түлш ойролцоогоор 10.7 кВт·ц /генератор 3.0-3.5/<br>1 литр бензин ойролцоогоор 8.8 -9.7 кВт·ц /генератор 2.0-2.5/ |
| E1.2 | | Цахилгаан | Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр) | 4,457.3 | 3843.8 | Мега Втц ‘000 | Банк 2025 онд төв оффисын болон нийт салбар, нэгжийн эрчим хүчний хэрэглээг дотооддоо тооцож, тайлагналаа. Мөн улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй цахилгаан түгээх сүлжээний байгууллагуудаас баталгаажсан байдлаар 2024 онд цахилгааны хэрэглээ 3,879.3 мян кВт, 2025 онд цахилгааны хэрэглээ 3,308.5 мян кВт/цаг байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 14.7 хувиар хэмнэсэн байна. Энэ нь эрчим хүчний зохистой хэрэглээ, эрчим хүчний хэмнэлтэй тоног төхөөрөмж ашиглах, ашигүй цаг хугацааны цахилгаан төхөөрөмжийн ашиглалтыг автоматаар унтраах, ажлын цагаар ажиллуулах, амралтын өдөр унтраах зэрэг эрчим хүчний хэмнэлт гаргах тоног төхөөрөмж суурилуулах зэрэг шалтгаанаас хэмнэлт үүссэн байна. |
| E1.3 | | Дулаан | Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр) | 655.3 | 1,102.8 | BTU & % Гкал | Ашигласан дулаан зарцуулалтын хэмжээг 2024 онд эвхэн Төв 1 байрны хувьд гаргасан бол 2025 онд Төв 1, 2, 3-р байрууд болон архивын байны тоолуурын заалтаар нийт хэрэглээ 4618 гДж тайлагнав. |
| E1.4 | | Түлш | Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр) | 51,117.0 | 364,372.6 | Литр/кг & %, ГЖоуль, Төгрөг | Түлшний зарцуулалтыг 2024 онд эвхэн төвийн хэмжээнд тайлагнасан бол системийн хэмжээнд 2025 онд 364,372.61 литр шатахуун хэрэглэсэн байна. Банкны хэмжээнд 2024, 2025 онд нийт 20 ширхэг цахилгаан автомашин худалдан авснаар түлш шатахууны зарцуулалтыг бууруулах арга хэмжээг авч, шатахуун зарцуулалт банкны системийн хэмжээнд 6 хувиар буурсан байна. |
| E1.5 | | Хүрэн эрчим хүч | СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь | 100% | 100% | % | Нүүрс |
| E1.6 | | Сэргээгдэх эрчим хүч | СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь | - | - | % | - |
| E2.1 | **Хүлэмжийн хийн ялгарал** | 3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт | Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн | 16,783.6 | 151,175.9 | CO2/тонн | • Банкны ялгаруулж буй хүлэмжийн хийг 2025 онд хамрах хүрээ 1, 2, 3-ыг хамруулан тооцсон.<br>• Хүлэмжийн хийн ялгаруулалтыг тооцохдоо ISO 14064-1:2018, ХХЯ-ын нягтлан бодох бүртгэлийн олон улсын тайлагналын стандарт, Эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах аргачлал (ЭХЗХ) болон Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн түншлэл /PCAF/-ээс гаргасан санхүүжүүлсэн ХХЯ-ыг тооцох стандартыг баримталсан. Дэлгэрэнгүйг Тогтвортой хөгжлийн 2025 оны тайлангийн “Хүлэмжийн хийн ялгарал” хэсгээс танилцана уу. |
| E2.2 | | 3.2 Бууруулсан хүлэмжийн хий | Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр) | 877.9 | 946.2 | CO2/тонн | • Банк хүлэмжийн хийг бууруулах зорилгоор ажилтнуудад зориулсан нийтийн тээврийн хэрэгслийг үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн.<br>• Цахилгаан тээврийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлсэн.<br>• Мөн ажилтнуудад зайнаас ажиллах боломжийг олгосноор банкны ажилтнуудын зорчих хөдөлгөөнөөс ялгарах хүлэмжийн хийг бууруулсан.<br>• Цахим үйлчилгээний хэрэглээг өргөжүүлснээр цаасан суурьтай үйл ажиллагаат орлох боломж бүрдэж, байгалийн нөөцийн хэрэглээг бууруулсан. Дэлгэрэнгүйг Тогтвортой хөгжлийн 2025 оны тайлангийн “Хүлэмжийн хийн ялгарал” хэсгээс танилцана уу. |
| E2.3 | | 3.3 Дүйцүүлэх арга хэмжээ / Карбон офсет/ | Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээны (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмийн хийг бууруулах гадны төслийг дэмжих гэх мэт)бууралт | 1,094.2 | 1,088.68 | CO2/тонн | Банк нь “Модыг Мод(а) болгоё-Ажилтан бүр нэг мод” аяныг жил бүр ажилтнуудынхаа дунд зохион байгуулж, 2025 онд нийт 4,772 ширхэг модыг тарьж ургуулсан. Мөн Тэрбум мод сантай хамтран ажиллаж, сар бүр гүйлгээний шимтгэлээс тодорхой хувийг 2022 оны 5-р сараас хойш тогтмол төвлөрүүлснээр Төрийн банкны хувьд 232,587.7 модыг тус тус тарьсан. Дэлгэрэнгүйг Тогтвортой хөгжлийн 2025 оны тайлангийн “Хүлэмжийн хийн ялгарал” хэсгээс танилцана уу. |

| Код | Бүлэг | Шалгуур үзүүлэлт | | Үзүүлэлт 2024 он | Үзүүлэлт 2025 он | Хэмжих нэгж | Нэмэлт мэдээлэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| E3.1 | Уур амьсгалын өөрчлөлт | Уур амьсгалын бодлого, журам | Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу? | Үгүй | Тийм | | Төрийн банк 2025 онд Эрсдэлийн удирдлагын бодлогод “Тогтвортой байдал, Уур амьсгалын эрсдэлийн удирдлага” бүлгийг шинээр нэмж, холбогдох заалтыг оруулж тусган, ТУЗ-ийн 2025.03.20-ны өдрийн 42 дугаар тогтоолоор батлуулан мөрдөж ажиллаж байна.<br>Тус онд Уур амьсгалын эрсдэлийн зөвлөх үйлчилгээ авч “Уур амьсгалын эрсдэлийн удирдлагын чиглэлээр 2026 онд хийгдэх ажлын төлөвлөгөө”-г мөрдөж ажиллаж байна. Дэлгэрэнгүйг Төрийн банкны Тогтвортой хөгжлийн 2025 оны тайлангийн “Уур амьсгалын эрсдэл” хэсгээс үзнэ үү. |
| E3.2 | | Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ | Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү? (сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт) | Үгүй | Тийм | | Монголбанкны Нэгдсэн Үндэсний Байгууллагын дэргэдэх “Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн түншлэл”-тэй хамтарсан “Төв банкийг ногоон болгоход бэлэн байдлын дэмжлэг үзүүлэх” төслийн хүрээнд банкны салбарын уур амьсгалын стресс тестийг туршилтаар системийн ач холбогдол бүхий банкуудын тоон мэдээлэлд үндэслэн анх удаа гүйцэтгэхээр төлөвлөн уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл (ган зудын эрсдэл, үерийн эрсдэл, Парисын хэлэлцээрийн зорилттой нийцүүлэн дэлхийн дулаарлын 2°C дотор барихтай холбоотой 3 сценарь) нь банкны зээлийн эрсдэлд нөлөөлөх судалгаа, аргачлалын баримт бичгүүдийг боловсруулан банкуудад ирүүлсэн. Тус аргачлалын дагуу банк уур амьсгалын өөрчлөлтийн сценарь шинжилгээг 2025 оны 1 дүгээр улиралд боловсруулан Монголбанканд хүргүүлсэн. Мөн Уур амьсгалын эрсдэлийн зөвлөх үйлчилгээний хүрээнд сценар шинжилгээг хийсэн бөгөөд зөвлөмжийн дагуух ажлуудыг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллаж байна. Дэлгэрэнгүйг Төрийн банкны Тогтвортой хөгжлийн 2025 оны тайлангийн “Уур амьсгалын эрсдэл” хэсгээс үзнэ үү. |
| E3.3 | | Эдийн засгийн хохирол | Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ | - | - | Төгрөг | Банканд 2025 онд уур амьсгалын эрсдэл, хохирол үүсээгүй болно. |
| E3.4 | | Уур амьсгалын хөрөнгө оруулалт | Уур амьсгалын өөрчлөлтийн эрсэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн | - | - | Төгрөг | - |
| E3.5 | | Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох | Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашиг ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон уу? | Үгүй | Тийм | | Уур амьсгалын эрсдэлийн зөвлөх үйлчилгээг 2025 онд авч улмаар “Уур амьсгалын эрсдэлийн удирдлагын чиглэлээр 2026 онд хийгдэх ажлын төлөвлөгөө”-г мөрдөж ажиллаж байна. |
| E4.1 | Ус | Усны хэрэглээ | Ашигласан усны нийт хэмжээ | 3’998 | 4’101 | м3 | Банкны төвийн 3 оффист 2025 онд 4101 куб.м ус хэрэглэсэн. УБ хотын салбар нэгжүүдийн хувьд тус тусдаа хариуцсан конторууд хяналт тавьж төлбөр тооцоог гаргаж ажилладаг. |
| E4.2 | | Хэмнэсэн ус | Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ | - | - | м3 | - |
| E4.3 | | Дахин боловсруулсан ус | Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь | - | - | % | - |
| E4.4 | | Хаягдал бохир ус цэвэрлэх | Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ | 3’998.0 | 4’101.0 | м3 | Төв цэвэрлэх байгууламж руу нийлүүлдэг. |
| E5.1 | Хатуу хог хаягдал | Хог хаягдал | Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ | 10.0 | 10.3 | тонн | 2025 онд өдөрт 13 уут хог хаягдал буюу 10296 кг хог хаягдал гарсан. |
| E5.2 | | Дахин боловсруулсан хатуу хог хаягдал | Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь | 6.9 | 2.4 | % | Төвийн байруудад 2024 оны 10 сараас дахин боловсруулах хог хаягдлыг цуглуулж эхэлсэн ба 2025 онд төвийн байруудаас нийт 210 кг хуванцар сав, 40 кг төмөр лааз цуглуулж тушаасан. |
| E5.3 | | Хортой хог хаягдал | Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно) | 5 | 0.2 | тонн | Тайлант онд 2025 оны актлагдсан цахилгаан хөрөнгүүдийг 2026 онд устгалд оруулахаар төлөвлөсөн. Төрийн банкны эмчээс ажлын 5 өдөрт дунджаар нийт 5 кг, жилд 240 кг аюултай хог хаягдал гардаг. Аюултай хог хаягдалд нэг удаагийн зүү, тариур, тарианы шил, дуслын шил, дуслын уут, хөвөн, боолт, резин бээлий бусад материалууд ордог. Эдгээр аюултай хог хаягдлыг гэрээт байгууллагатай хамтарч зориулалтын хогны машинаар зөөвөрлөж устгалд оруулдаг. |

| Код | Бүлэг | Шалгуур үзүүлэлт | | Үзүүлэлт 2024 он | Үзүүлэлт 2025 он | Хэмжих нэгж | Нэмэлт мэдээлэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| E6.1 | Биологийн олон янз байдал | Ногоон байгууламж, төлөвлөлт | Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн зээмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь | - | - | % | - |
| E6.2 | | Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах | Хамгаалсан төрөл зүйлийн тоо | - | - | Төрөл зүйлийн тоо | Зэрлэг ан амьтныг хамгаалах зорилгоор “Хүрээлэн төсөл”-тэй хамтран ажиллах гэрээг байгууллаа. |
| E6.3 | | Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа | Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг зээмшиж, түрээслэсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь | - | - | % | - |
| S | НИЙГМИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД | | | | | | |
| S1.1 | Хүний нөөц | Хүний нөөцийн тогтвортой байдал | Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах) | 13.5% | 16.5% | % | Тайлант онд ажлаас гарсан ажилтны тоо өмнөх онтой харьцуулахад 3%-аар өссөн байна. |
| S1.2 | | Шинээр бий болгосон ажлын байр | Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо | 52 | 22 | Тоо | Батлагдсан орон тоонд багтаан чиг үүрэг, орон тоог зохистой хуваарилах замаар 2025 онд шинээр нийт 22 ажлын байрыг нэмэгдүүлсэн. |
| S1.3 | | Сургалт | Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг | 5.6 | 2.6 | цаг | 2025 онд нийт 156 удаагийн 7,096 цагийн сургалтыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, давхардсан тоогоор 12,047 ажилтан /Банкны төв - 1496, УБ - 3766, ОН - 6785 / хамрагдсан. |
| S2.1 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА) | ХАБЭА-н бодлого | ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? | Тийм | Тийм | | Банк 2023 онд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмыг тусад нь батлуулан, хэрэгжүүлж байна. Дэлгэрэнгүйг Төрийн банкны Тогтвортой хөгжлийн 2025 оны тайлангийн “Тогтвортой үйл ажиллагаа” хэсгээс үзнэ үү. |
| S2.2 | | Осол аваар | Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь | 0.05% | 0.16% | % | Тайлант онд Улаанбаатар хотод 2, орон нутагт 4 хүн үйлдвэрлэлийн осолд өртөж, бэртсэн тохиолдол гарсан осолд өртсөн хүн бүр дээр ослын акт гарсан. Тухайн аймаг, дүүргийн Хөдөлмөр халамжийн хэлтэст ослийн акт хүргүүлж улсын байцаагчаар баталгаажуулж НДГ-аас цалин мөнгийг 100% олгуулах арга хэмжээ авч ажиллаасан ХАБЭА ISO 45001:2018 стандартыг Төрийн банканд нэвтрүүлж баталгаажуулалтын аудит хийлгэж ямар нэгэн үл тохиролгий өөрийн орон болон олон улсын баталгаажуулалтын итгэмжлэгдсэн байгууллагаас 3 жилийн хугацаатай гэрчилгээ хүлээн аван ажиллаж байна. |
| S2.3 | | ХАБЭА-н сургалт | Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг | 0.01 | 0.02 | цаг | Нэг ажилтанд ногдох ХАБЭА сургалт жилд 0.02 байна. |
| S2.4 | | Эрүүл мэндийн хөтөлбөр | Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр | 2,516 | 2,637 | хүн | Ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд нийт 2,637 ажилтан үзлэг, шинжилгээнд хамрагдлаа. |
| S3.1 | Эрх тэгш байдал | Жендэрийн бодлого, журам | Жендэрийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? | Тийм | Тийм | | ТУЗ-ийн 2024.06.21-ний өдрийн №35 тоот тогтоолоор батлагдсан Хүний нөөцийн бодлогын 9-р бүлэг болгон “Хүний эрх ба жендэр”-ийн бодлогыг шинээр боловсруулан батлсан. Тус бодлогод шийдвэр гаргалт болон үйл ажиллагааны бүхий л түвшинд хүний эрх болон жендэрийн эрх тэгш байдлыг ханган, ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд жендэрийн тэгш бус байдлыг бууруулах, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэн ажиллах заалтыг тусгасан. |
| S3.2 | | Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам | Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? | Тийм | Тийм | | ТУЗ-ийн 2024.06.21-ний өдрийн №35 тоот тогтоолоор батлагдсан Хүний нөөцийн бодлогын 9-р бүлэг болгон “Хүний эрх ба жендэр”-ийн бодлогыг шинээр боловсруулан батлсан. Тус бодлогод ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажлын байрны бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэх, бэлгийн дарамт, аливаа хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, гомдол хүлээн авах, гомдлыг барагдуулах, зөрчлийг шийдвэрлэх хяналтын тогтолцоог бүрдүүлэх заалтыг тусгасан. Банкны Хөдөлмөрийн дотоод журмын хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд баримтлах зарчим, ажилтны эрх үүрэг, хориглох зүйл, ноцтой зөрчил гэсэн зүйлүүдэд жендер, бэлгийн дарамтын эсрэг арга хэмжээний заалтууд тусгагдсан. |

| Код | Бүлэг | Шалгуур үзүүлэлт | | Үзүүлэлт 2024 он | Үзүүлэлт 2025 он | Хэмжих нэгж | Нэмэлт мэдээлэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| S3.3 | Эрх тэгш байдал | Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам | Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? | Тийм | Тийм | | Банкны Хүний нөөцийн бодлого, Хөдөлмөрийн дотоод журмаар ажилтны ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шуд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг тус тус хориглосон заалт тусгагдсан. |
| S3.4 | | Ажилтнуудын хүйсийн харьцаа | Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь | 30/70 | 30/70 | % | Ажилтнуудын хүйсийн харьцаа эрэгтэй 29.8%, эмэгтэй 70.2%. |
| S3.5 | | Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа | Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа | 70/30 | 64/36 | % | ТУЗ-ийн эрэгтэй, эмэгтэй дарга, гишүүдийн хүйсийн харьцаа эрэгтэй 64.3%, эмэгтэй 35.7%. |
| S3.6 | | Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа | Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа | 71/29 | 86/14 | % | Гүйцэтгэх удирдлагын түвшний хүйсийн харьцаа эрэгтэй 85.7%, эмэгтэй 14.3%. |
| S3.7 | | Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа | Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа | 29/71 | 29/71 | % | Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа эрэгтэй 28.6%, эмэгтэй 71.4%. |
| S3.8 | | Жендэрт суурилсан цалингийн зөрүү | Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа | 50/50 | 50/50 | харьцаа | Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа тэнцүү |
| S4.1 | Хүртээмжтэй байдал | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? | Тийм | Тийм | | Банк нь 2024 онд Хүний нөөцийн бодлогодоо “Хүний эрх ба жендэр”-ийн бүлгийг шинээр тусгаж, баталсан бөгөөд тус бодлогод хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тохирсон ажлын байраар хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ялгаварлан гадуурхах байдал үүсэхээс сэргийлэх болон тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх заалтыг тусгасан. Мөн Хөдөлмөрийн дотоод журамд хөгжлийн бэрхшээлтэй ажилтан болон хөгжлийн бэрхшээлтэй эхнэр, нөхөр, хүүхэдтэй ажилтан улиралд 1 өдрийн цалинтай чөлөө олгох зохицуулалт тусгагдан мөрдөж байна. |
| S4.2 | | Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд | Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь | 2% | 2.9% | % | Банкны хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 91 ажилтан ажиллаж байна. |
| S4.3 | | Оффисын хүртээмж | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу | Тийм | Тийм | | Төв байр нь налуу шаттай бөгөөд Улаанбаатар болон Орон нутгийн нийт 489 нэгжээс 447 нэгж суугаа барьертай, 81 нэгж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэмдэглэгээ бүхий автомашины зогсоолтой, 229 нэгж налуу замтай, 38 нэгж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөөтэй, 49 нэгж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хонх байршуулан ажиллаж байна. |
| S4.4 | | Торгууль | Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо | - | - | Төгрөг | Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчил байхгүй. |
| S5.1 | Нийгмийн хариуцлага ба ил тод байдал | Оролцогч талуудын оролцооны засаглал | Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу? | Тийм | Тийм | | “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар “Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого” батлагдаж, “Төрийн банк” ХК-ийн оролцогч талууд болон иргэдүйн хөрөнгө оруулагч, санхүүгийн зах зээлд оролцогч этгээдэд банкны үйл ажиллагааны мэдээлэл, стратегийн зорилтын хэрэгжилт, засаглал, хэтийн төлөв, санхүүгийн гүйцэтгэл, үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц үйл явдлын талаарх мэдээллийг хүргэж, хамтран ажиллах бодлогыг тодорхойлсон.<br>Түүнчлэн, “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолын хавсралтаар “Хувьцаа эзэмшигч, олон нийтэд Төрийн банк ХК-ийн мэдээллийг ил тод мэдээлэх, тайлагнах журам” батлагдсан бөгөөд тус журмын дагуу банкны үйл ажиллагааны талаарх мэдээллийг банкны хувьцаа эзэмшигч, олон нийтэд мэдээлэх, тайлагнах, мэдээллийн төрөл, хэлбэрийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулж байна.<br>Бодлогын линк: https://www.statebank.mn/personal/news/33804<br>https://heyzine.com/flip-book/06e5686a92.html<br>https://heyzine.com/flip-book/08d53c58f4.html |

| Код | Бүлэг | Шалгуур үзүүлэлт | | Үзүүлэлт 2024 он | Үзүүлэлт 2025 он | Хэмжих нэгж | Нэмэлт мэдээлэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| S5.2 | Нийгмийн хариуцлага ба ил тод байдал | Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам | Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана) | Үгүй | Үгүй | | - |
| S5.3 | | Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/журам | Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу? | Тийм | Тийм | | Харилцагчаас ирсэн санал гомдлыг “Харилцагчийн мэдээллийн төвийн үйл ажиллагааны журам”-аар зохицуулдаг. Ажилтнаас ирсэн санал, гомдлыг “Ажилтнаас гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.<br>Мөн банк “Шүгэл үлээх үйл ажиллагааны журам”-ыг 2024 онд баталж, харилцагч болон ажилтнуудаас холбогдох мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэн ажиллаж байна.<br>2025 онд “Шүгэл үлээх бодлого”-ыг баталж банкны албан ёсны цахим хаяг (www.statebank.mn)-т байрших “Шүгэл үлээх суваг”-аар дамжуулан авдаг болж эхэлсэн.<br>Ажилтнуудын хувьд Гүйцэтгэх захирлын 2023.04.12-ны өдрийн А/176 тоот тушаалаар батлагдсан “Ажилтнаас гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж байна. |
| S5.4 | | Олон нийтэд ил тод мэдээлэх | Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу? | Тийм | Тийм | | Харилцагчаас санал, хүсэлт, гомдол хүлээн авч журмын дагуу холбогдох газар, хэлтэс, алба, салбар, нэгж рүү илгээн шийдвэрлүүлж, харилцагчид хариу өгсөн эсэхэд хяналт тавьж ажилладаг.1. Лавлах утас: 1800-1880. Онлайн туслах: Линк: https://www.statebank.mn:8080/phplive.php?&token=7924f5eab6347addf2331a67bee843593. Гялсбанк 3.0 санал хүсэлт: Гялсбанк үйлчилгээнд нэвтрэн ороод Бусад цэсийн Тусламж - Санал хүсэлт хэсэг;4. Facebook chat: https://www.facebook.com/StatebankMN - Message5. Цахим шуудан: contact@statebank.mn6. Шүгэл үлээх сувар: https://www.statebank.mn/personal/news/33934 |
| S5.5 | | Ажилчид/олон нийтийн санал гомдол | Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдэрлэсэн хувь | 94.0% | 99.6% | % | Тайлант хугацаанд ажилтнуудаас 499 өргөдөл хүлээн авч, 425 өргөдлийг шийдвэрлэсэн буюу 85.1%-тайгаар санал, гомдлыг шийдвэрлэсэн.<br>2025 онд харилцагчдаас ХМТ /1800-1881/-д нийт 8,989 санал, хүсэлт, гомдол бүртгэгдсэн. Нийт асуудлын 8,952 буюу 99.6% шийдвэрлэгдсэн байна. |
| S5.6 | | Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт | Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь | 1.4 | 0.004 | % | Төрийн банк нь 2025 онд Нийгмийн хариуцлагын хөтөлбөр, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн бөгөөд дэлгэрэнгүйг Төрийн банкны Тогтвортой хөгжлийн 2025 оны тайлангийн “Тогтвортой үйл ажиллагаа” хэсгээс үзнэ үү. |
| S6.1 | Тогтвортой өртгийн сулжээний менежмент | Худалдан авалтын бодлого, журам | Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжыг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? | Тийм | Тийм | | Банкны “Тогтвортой хөгжлийн журам”-ын Худалдан авалтын үйл ажиллагаа хэсэгт ногоон худалдан авалтын талаар зохицуулсан байдаг. “Төрийн банкны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журам”-д худалдан авалт хийх, техникийн тодорхойлолт боловсруулахад дээрх журамд заасны дагуу зохион байгуулах талаар тусгаж зохицуулсан болно. |
| S6.2 | | Дотоодын худалдан авалт | Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь | 94.1 | 97.5% | % | 2025 онд нийт худалдан авалтын 97.5%-д дотоодын байгууллага, иргэнээс худалдан авалтыг хийсэн байна. |
| S6.3 | | Тогтвортой, ногоон худалдан авалт | Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгууруур сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь | 27.5 | 39% | % | 2025 онд нийт худалдан авалтын 39%-д тогтвортой худалдан авах ажиллагааны шалгуур үзүүлэлт тавигдаж, худалдан авалтын үйл ажиллагаа хийсэн. |

| Код | Бүлэг | Шалгуур үзүүлэлт | | Үзүүлэлт 2024 он | Үзүүлэлт 2025 он | Хэмжих нэгж | Нэмэлт мэдээлэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| G | ЗАСАГЛАЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД | | | | | | |
| G1.1 | Авилгал болон ёс зүй | Авилга, хээл хахуулийн эсрэг бодлого журам | Авилгын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу? | Тийм | Тийм | | Төрийн банк ХК-ийн Хувь нийлүүлэгчдийн хурлын тогтоолоор батлагдсан “Төрийн банк хувьцаат компанийн дүрэм”, ТУЗ-ийн хурлаар батлагдсан “Дотоод ашиглан, залилангийн эрсдэлийн удирдлагын бодлого”, “Төрийн банкны ажилтны ёс зүйн дүрэм”, Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан “Төрийн банкны ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”, “Хөдөлмөрийн дотоод журам”, “Харилцагч, хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааны журам”, Шүгэл үлээх үйл ажиллагаат зохицуулах журам” болон “Төрийн банкны дотоод ашиглан, залилангийн эрсдэлийн удирдлагын журам”-ыг мөрдөж ажилладаг.Мөн түүнчлэн, 2023 онд “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг батлагдсан бөгөөд тус журамд ТУЗ-ийн гишүүдийн ёс зүй, баримтлах зарчмыг тусган ТУЗ-өөс баталж буй бодлого, журмуудад ёс зүйн, авлигын эсрэг зүйл, заалтуудыг тусган батлагдсан.ТУЗ-ийн 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 67 дугаар тогтоолын хавсралтаар Төрийн банкны ажилтны Ёс зүйн дүрэм, 2025 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн 71 дүгээр тогтоолын хавсралтаар “Шүгэл үлээх бодлого”-ыг тус тус батлагдсан. https://www.statebank.mn/personal/news/33804 |
| G2.1 | Компанийн засаглал | Удирдах зөвлөлийн хараат бус байдал | Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь | 44 | 44 | % | “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар шийдвэрээр “Төрийн банк” ХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулж, улмаар банкны ТУЗ-ийн 9 гишүүний 4 нь хараат бус гишүүн байна гэж заасан. |
| G2.2 | | Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх | Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу? | Тийм | Тийм | | “Төрийн банк” ХК-ийн дүрэм, Хяналтын зөвлөлийн ажиллах журам болон Хувьцаа эзэмшигчдийн хурлын журмын дагуу зохицуулагдана.<br>Линк: https://www.statebank.mn/personal/news/33804 |
| G2.3 | | Компанийн засаглалын бодлого, журам | Компанийн засаглалын бодлого, журам бий юу? | Тийм | Тийм | | Төрийн банкны “Зохистой засаглалын журам”-ыг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>“Төрийн банк” ХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглалын албаны ажиллах журам”-ыг батлан ТУЗ-ийн дэргэд Засаглалын албыг байгуулан ажиллаж байна.<br>“Төрийн банк” ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 26 дугаар тогтоолын хавсралтаар Компанийн засаглалын кодексийг хэрэжүүлэх хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна.<br>Журмын линк: https://www.statebank.mn/personal/news/33804 |
| G3.1 | Комплайнс | Комплаенсын бодлого | Комплаенсын бодлого, журам бий юу? | Тийм | Тийм | | ТУЗ-с баталсан Комплайнсын бодлоготой, тус бодлогыг 2024 онд шинэчлэн баталсан.<br>Бодлогын линк: https://www.statebank.mn/personal/news/33804 |
| G3.2 | | Комплаенсын хөтөлбөр | Комплайнсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу? | Тийм | Тийм | | ТУЗ-с батлагдсан Төрийн банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй. |
| FS | НЭМЭЛТ САЛБАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД (ТАНАЙ КОМПАНИД ХАМААРАХ САЛБАРЫН АСУУЛТУУДЫГ БӨГЛӨНӨ ҮҮ) | | | | | | |
| FS1 | Санхүүгийн үйлчилгээ | Санхүүгийн хүртээмж | Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх болон санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах санаачилга, арга хэмжээнд оролцсон хүмүүсийн тоо, жилээр | 100,633 | 105,093 | хүн | Салбар нэгжийн инкубатор төв хариуцсан ажилтнуудаар дамжуулан 2025 онд 2,754 бизнес эрхлэгч бойжигч, 11,540 бизнес эрхлэгч, 71,469 оюутан сурагч, 19,330 хүүхэд залууст нийт 105,093 иргэнд, үүнээс тусгай хэрэгцээт 54 сурагчдад санхүүгийн боловсрол олгох сургалт, зөвлөгөө мэдээлэл хүргэн ажилласан. |
| FS2 | | БОНЗ-ын эрсдэлийн менежмент | БОНЗ-ын эрсдэлийн шалгуур болон хориотой үйл ажиллагааны жагсаалтаар үнэлсэн гүйлгээний хувь | 2.9 | 4.3 | % | Тайлант онд 333 харилцагчийн 172.6 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлтэд БОНЗ-ын үнэлгээ хийж ажиллалаа.<br>Банк 150 сая төгрөгөөс дээш дүнтэй, 12 сараас дээш хугацаатай бизнесийн болон төслийн зээлүүдэд БОНЗ-ын үнэлгээ хийж байна. |
| FS3 | | Тогтвортой санхүүжилт | Нийт зээлийн багцад эзлэх ногоон/ТХЗ таксономийн ангилалд нийцсэн ногоон/тогтвортой зээлийн эзлэх хувь | 1.53 | 2.8 | % | Ногоон зээлийн багцын үлдэгдэл тайлант жилийн эцсийн байдлаар 116.9 тэрбум төгрөгт хүрч, нийт зээлийн багцын 2.80 хувийг эзэлж байгаа нь өмнө оны мөн үетэй харьцуулахад 118.20 хувиар буюу 63.3 тэрбум төгрөгөөр өссөн байна. |